

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

№	Товч агуулга	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Биелэлт	Хийсэн ажлын мэдээллийг цахим хуудсанд байршуулсан линк	Хэрэгжээгүй шалтгаан	Хувь
1	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах салбар хороодын ажлын уялдаа холбоог хангаж, нэгдсэн төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг сайтар хангаж, газар дээр нь явж танилцах.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар	Хэрэгжүүлэгч агентлагууд, Монгол наадам цогцолбор, бусад чиг үүргийн байгууллагууд	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулахтай холбоотой нийслэлийн Засаг даргын захирамж, удирдамжийн хүрээнд холбогдох чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулан, хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллана.			30
2	"Хотын иргэдийн баяр - Хүрээ даншиг" наадмын нэгдсэн арга хэмжээг сайтар зохион байгуулж, иргэд, олон нийтийн аюулгүй байдал, худалдаа үйлчилгээнд онцгой анхаарч ажиллах.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлагууд	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан "Хотын иргэдийн баяр - Хүрээ даншиг" наадмын үеэр Хүй долоон удагт худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих ажлын удирдамжийн хүрээнд хоол үйлдвэрлэл 8, худалдаа 2, явуулын үйлчилгээтэй 4 нийт 15 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан, хяналт тавин ажилласан.			100

3	<p>Япон улсын Эзэн хаан нийслэл, Улаанбаатар хотод айлчлахтай холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, авто зам, гудамж, явган замын тохижилтын ажлуудтай газар дээр нь явж танилцах.</p>	<p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба</p>	<p>Дүүргийн Засаг дарга нар</p>	<p>“Геологийн төв лабораторийн уулзвараас офицеруудын ордны тойрог хүртэл 11.6 км нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, 3 дугаар хэсэг (Улаанбаатар хот, ЭТӨЧ, Москвагийн гудамж)” төсөл арга хэмжээг Сант-Өндөр ХХК хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд хийгдэх Баруун 4-н замын уулзвараас Төв шуудангийн уулзвар хүртэлх явган замын тохижилтын ажилд явцын хяналт тавин ажиллаж байна.</p>	50
4	<p>Явган хүний замын тохижилтын ажлыг эрчимжүүлж, газар дээр нь ажиллаж, хэрэгжилтэд хяналт тавих.</p>	<p>Нийслэлийн удирдлагууд Засаг даргын зөвлөхүүд, Дүүргийн Засаг дарга нар</p>	<p>Хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар</p>	<p>“Геологийн төв лабораторийн уулзвараас офицеруудын ордны тойрог хүртэл 11.6 км нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, 3 дугаар хэсэг (Баруун 4-н замын уулзвараас Төв шуудангийн уулзвар хүртэл)” Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа явган замын ажлын үзлэг шалгалтыг 7 сарын 4-ны өдөр зохион байгуулахаар хуваарь гарган батлуулан ажиллаж байна.</p>	30

5	<p>Замын хөдөлгөөний хяналтын камерын бүртгэж байгаа зөрчлийн арга хэмжээг чанаржуулж, автозамын тэмдэг, тэмдэглээг стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг эрчимжүүлэх.</p>	<p>Замын хөдөлгөөн удирдлагын төв, Нийслэлийн Замын хөгжлийн газар</p>	<p>Дүүргийн Засаг дарга нар</p>	<p>Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар болон Чингэлтэй дүүргийн теле камерын хяналтын дэд төвтэй хамтран аж ахуйн нэгж байгууллагын гадна тал болон гудамж талбайд шинээр байршуулах теле хяналтын камерын анхааруулах шар тэмдгийн 296 цэгийн судалгааг гарган нэгтгэн хүргүүлсэн. Зөрчил их үйлдэгддэг зам орчмын 13 байршилд судалгаа гарган камер байршуулах саналыг Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд болон Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Тээврийн хяналт, төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс тус тус хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрийн 1-24 дүгээр хорооны гудамж замын тэмдэг тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж нийслэлийн замын хөгжлийн газарт шинээр байрлуулах нийт 38 ширхэг тэмдгийг Монгол Улсын "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596:2014 стандарт нийцүүлэн байрлуулах саналыг хүргүүлж, "Добо МБД" ХХК-тай хамтран тэмдгийн хандалт буруу, хазайсан, унасан нийт 310 тэмдэгт засвар арчлалтын ажил хийж, шаардлага хангахгүй 24 тэмдгийг хурааж шинээр 84 ширхэг тэмдэг байрлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн теле хяналтын камерын нэгдсэн төвөөс (Ногоон бус) өдөр бүр зөрчлийг камераар илрүүлж, тус хэлтэст шилжүүлэн ажиллаж байгаа.Энэ оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс энэ оны 06 дугаар сарын хооронд нийт 186 жолоочид 3,720,000 төгрөгийн бэлэн бус торгууль оногдуулж ажилласан байна.</p>	100
---	--	--	---------------------------------	--	-----

6	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын газар чөлөөлөлтийг эрчимжүүлэх.	Нийслэлийн газар зохион байгуулалтын албан арга	Дүүргийн Засаг дарга нар	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын газар чөлөөлөлтийг эрчимжүүлэхээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албан арга 2025-04-24 өдөр 01/1126 дугаартай Газар чөлөөлөлтийг эрчимжүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн.	30
7	Үндэсний их баяр наадмаас өмнө ус тогтдог байршлуудыг засварлаж, хөв цөөрөм байгуулах бэлтгэл ажлыг хангаж, дунд голын далангийн ажлыг шуурхай зохион байгуулах.	Геоземи, усны барилга, байгууламж ийн газар ОНӨААТҮГ	Дүүргийн Засаг дарга нар	Дүүргийн нутаг дэвсгэрт бороо орсны улмаас бөглөрөх магадлалтай хог цуглардаг далан суваг, гуу жалгыг цэвэрлэх 96 ажил, мөн борооны ус тогтдог газрууд, явган замуудыг засварлах шаардлагатай 81 ажлыг 1-ээс 24 дүгээр хороодоос авч нэгтгэн Геоземи, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ-т 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 03/1973 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	50
8	2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хотула аппликейшнийг ашиглалтад оруулж, сайжруулсан шахмал түлшний түгээлтэд хяналт тавих.	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв	Дүүргийн Засаг дарга нар	Сайжруулсан шахмал түлшний түгээлт болон Хотула аппликейшн одоогоор ашиглагдаж эхлээгүй байгаа тул хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	ХТХБ

9	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт ажиллагаа явуулж байгаа авто замын нүүрний эгнээн дэх дугуй засвар, тос, тослогоо, вьетнам засварын газруудыг нэгдсэн журмаар цэгцлэх ажлыг зохион байгуулах.</p>	<p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хяналт шалгалтын газар, Газар зохион байгуулалтын н алба, Дүүргийн Засаг дарга нар</p>	<p>Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар, Замын цагдаагийн газар, Бусад байгууллагууд</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/4050 дугаар албан бичгийн хүрээнд дүүргийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй газар өмчилсөн иргэд нь өмчийн газраа зориулалт бусаар тос тосолгооны материал худалдаалах, авто засвар, дугуй засвар зэргээр ашиглаж байгаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байгаад холбогдох байгууллагуудтай хамтран хяналт хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	30
10	<p>Нийслэлийн бүтэц, дүүргийн чиг үүргийг хороодод шилжүүлэхтэй холбоотой бүтцийг танилцуулах.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газар</p>	<p>Дүүргийн Засаг дарга нар</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/222 дугаар Эрх шилжүүлэх тухай захирамжаар 24 хороодын нутаг дэвсгэрт хийж гүйцэтгэх нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн тохижилт, засвар, хотын стандартыг мөрдүүлэх 78 ажлыг баталж, чиг үүргийн дагуу "Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ-т шилжүүлсэн. 2025 оны 07 дугаар сарын 01-ний байдлаар 1-10 дугаар хороо болон 24 дүгээр хорооны засварлах ажлууд эхэлж, хороо тус бүрт ажлын гүйцэтгэл 20-60 хувьтай байна.</p>	50

11	Төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, шоу, тоглолтын арга хэмжээнээс авч буй татварын орлогын талаар танилцуулах.	Нийслэлийн Татварын газар	Дүүргийн Засаг дарга нар, Бусад орлого бүрдүүлэгч байгууллагууд	2025 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар өссөн дүнгээр: Улсын төсөвт 57,754,661.73 мянган төгрөг төвлөрүүлэхээс 55,650,345.40 мянган төгрөг төвлөрүүлж 96.36%, Нийслэлийн төсөвт 14,830,614.12 мянган төгрөг төвлөрүүлэхээс 11,447,842.39 мянган төгрөг төвлөрүүлж 77.19%, Дүүргийн төсөвт 140,908,400.00 мянган төгрөг төвлөрүүлэхээс 136,426,474.14 мянган төгрөг төвлөрүүлж 96.82%-ийн биелэлттэй төсвийн орлогыг жигд ханган биелүүлж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт томоохон шоу, тоглолтын арга хэмжээ зохион байгуулаагүй байна.		90
12	Нийслэлийн Байгаль орчны газраас хог хаягдлын Улсын байцаагчийн сонгон шалгаруулалтыг зарласан тул дүүргүүд хүмүүсээ оролцуулах.	Дүүргийн Засаг дарга нар	-	Нийслэлийн Байгаль орчны газраас хог хаягдлын Улсын байцаагчийн сонгон шалгаруулалтыг зарласантай холбогдуулан 2-3 байцаагчид санал хүргүүлж, Чингэлтэй дүүргийн сайтад зар байршуулан ажилласан.		70

13	Нийслэлийн хэмжээнд "Сүү хөтөлбөр"-ийг боловсруулж, танилцуулах.	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Мал эмнэлгийн газар	Дүүргийн Засаг дарга нар, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар	"Сүү хөтөлбөр"-ийн хүрээнд дүүргийн Засаг даргын 2025 оны "Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай түр сүүдрэвчтэй, үйлчилгээ болон түргэн хоолны цэгийн байршил батлах тухай" А/221 дүгээр захирамжаар дүүргийн 5 дугаар хороо Тусгаар тогтнолын талбай, Тэди төвийн дэргэд сүү, зайрмагны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Цуна Монгол Дай" ХХК-ийн киоскийг байршуулан үйл ажиллагааг дэмжиж, "Сүү хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.			70
Үнэлгээний дундаж 58.3%							

Үнэлгээний дундаж



ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

М.НАВЧАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.БУЯН-ӨЛЗИЙ

НЭГТГЭЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН